БАТЛАВ
"ХҮНС ХАНГАМЖ ТӨВ" ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Н.УУГАНБАЯР

2020 оны......сарын......өдөр

# 2020 ОНЫ ТОДОТГОЛ СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЦЭЦЭРЛЭГҮҮДИЙН ГОЙМОН НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ХАРЬЦУУЛАЛТЫН ТЕНДЕР

Харьцуулалтын тендерийн дугаар ХХТ/202006009/01

## Хоёр. **ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА**

| | | |
|---|---|---|
| **1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа** | 1.1. | Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| **2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт** | 2.1. | Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна. |
| | 2.2. | Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ. |
| | 2.3. | Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ. |
| **3. Тендерийн иж бүрдэл** | 3.1. | Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:<br>(а) Үнийн санал: Тендер оролцогч нь үнийн саналыг маягтын дагуу бөглөж ирүүлэх<br>(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь ;<br>(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;<br>(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;<br>(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.] |
| **4. Тогтмол үнэ** | 4.1. | Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгөөр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| **5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд** | 5.1. | Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана. |
| | 5.2. | Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| **6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа** | 6.1. | Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |

| | | |
|---|---|---|
| **7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх** | 7.1. | Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ. |
| | 7.2. | Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь ***ТШӨХ-д*** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ. |
| | 7.3. | Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. |
| **8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл** | 8.1. | Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна. |

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

| ТӨӨЗ-ны холбогдох заалт | Шалгуур үзүүлэлт |
|---|---|
| **ТӨӨЗ 1.1** | Захиалагч нь: **Хүнс хангамж төв ОНӨААТҮГ**<br>• Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2019 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлан<br>• Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: 2019 он<br>• Борлуулалтын хэмжээ: Тендерт оролцогчийн сүүлийн 2019 оны борлуулалтын орлого нь тухайн тендерт санал болгож байгаа үнийн дүнгээс 40% -с багагүй байх<br>• Гүйцэтгэгчээр ажилласан байх жилийн тоо: 2019 оны хугацаанд санал болгож буй үнийн дүнгийн 40%-с багагүй дүнтэй барааны нийлүүлэгчээр багадаа 1 удаа ажилласан туршлагатай байх шаардлагатай.<br>• Гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмжийн жагсаалт. Үүнд: Захиалгат бараа бүтээгдэхүүнийг хуваарийн дагуу агуулахад тээвэрлэн хүргэх стандарт, эрүүл ахуйн шаардлага хангасан тээврийн хэрэгсэлтэйг нотлох, тээврийн хэрэгслийн гэрчилгээг нотариатаар баталгаажуулан ирүүлнэ.<br>• Ашигтай ажилласан байх жилийн тоо: 2019 он<br>• Барааг нийлүүлсний дараах засвар, үйлчилгээ:<br>Үүнд:<br>    • Бүтээгдэхүүний сав баглаа боодол гэмтсэн<br>    • Стандарт шаардлага хангаагүй<br>    • Бүтээгдэхүүний хадгалалтын хугацаа дуусах дөхсөн /тухайн бүтээгдэхүүний хадгалалтын хугацааны 1/3 хугацаа нь үлдсэн байх/ болон дууссан бол тухайн бүтээгдэхүүнийг солиулах<br>    • Бүтээгдэхүүнийг хүлээн авах үед мэдэгдэх боломжгүй байсан далд гэмтэл зэрэгт доголдлыг арилгуулах, гэмтэл доголдолгүй ижил төрлийн стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүнийг солиулах<br>    • Бусад |
| **ТӨӨЗ 2.1** | Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:<br><br>Цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын 5 кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (PDF)-ээр илгээнэ.<br><br>Огноо: ***2020 оны 7 дугээр сарын 1-ны өдөр***<br><br>Цаг: ***10 цаг 30 минут*** |

| | |
|---|---|
| **ТОӨЗ 2.1** | Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:<br><br>Байгууллагын хаяг: ***БГД 20-р хороо Москва гудамж Фужи алтайн 3 давхар***<br><br>Огноо: ***2020 оны 7 дүгээр сарын 1-ны өдөр***<br><br>Цаг: ***11 цаг 00 минут*** |
| **ТОӨЗ 2.3** | Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:<br>1. ***Үнийн санал тендерийн маягтын дагуу ирүүлэх /жишиг маягт***<br>2. **Улсын бүртгэлийн гэрчилгээний эхээс татсан хуулбар.**<br>3. ***Үнийн хуваарийг баталгаажуулан сараар ирүүлнэ. МАЯГТ №: ТШМ-2А, 2Б, 2В-ийн аль тохирохыг сонгох,***<br>4. ***Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарийг маягтад заасан хугацааны дагуу баталгаажуулан ирүүлнэ.***<br>5. ***Тухайн санал болгож буй багцын барааг нийлүүлэх нөөц нь үнийн дүнгийн 30% тай тэнцэх хэмжээний нотлох баримт ирүүлэх /Фото зургийн хамт/***<br>6. ***Татварын байгууллагын өргүй тухай тодорхойлолт /Тендер нээсэн өдрийн байдлаар өргүй байна./***<br>7. ***Өөрийн эзэмшлийн агуулах зоорины мэдээлэл ирүүлэх /үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний хуулбар, түрээсийн бол түрээсийн гэрээ.***<br>8. ***Мэргэжлийн хяналтын байцаагчийн агуулах, зоорины эрүүл ахуйн орчны талаар гаргасан дүгнэлт***<br>9. ***Санал болгож буй бүтээгдэхүүний гарал үүсэл болон ариун цэврийн гэрчилгээ, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 9.1-д заасан ул мөр мөрдөн тогтоох бүртгэлийн хуудас хөтөлж бүртгэл ирүүлэх***<br>10. ***Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар, Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын төв лабораторийн санал болгож буй бүтээгдэхүүнд хийсэн шинжилгээ. /Нийлүүлэгч компани өөрийн нэр дээр шинжилгээнд хамрагдсан байх***<br>11. ***Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолт***<br>12. ***Шүүхийн төрөлжсөн архивын лавлагаа***<br>13. ***Харилцагч банкнуудаас /Улсын бүртгэлийн гэрчилгээнд бүртгэлтэй болон бүртгэлгүй бүх банк / хугацаа хэтэрсэн зээл болон зээлийн хүүгийн өргүй талаарх тодорхойлолт***<br>14. ***Тендерийн баримт бичгийн 5, 6 дугаар бүлэгт заагдсан гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл ирүүлнэ***<br>15. ***Захиалагч тендерт оролцогчид Шүүхийн шийдвэр гүйцэтгэх, Шүүх төрөлжсөн архив, Татвар, Нийгмийн даатгал, харилцагч банк болон бусад байгууллагаас мэдэгдэл авахад татгалзах зүйлгүй талаарх мэдэгдэл.***<br>16. ***Олон нийтэд мэдээллэхэд татгалзах зүйлгүй тухай албан бичиг***<br>17. ***Гэрээг хэрэгжүүлэх удирдах болон техникийн голлох боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл ирүүлэх: Маягт №ТШМ-5 д Үүнд:Тендерт оролцогч нь дор хаяж***<br>• ***Төслийн удирдагч-1***<br>***/ Жич:***<br>***-Тендерт шаардсан материалын аль нэгийг ирүүлээгүй тохиолдолд тухайн тендерээс татгалзах үндэслэл болно.*** |

| | |
|---|---|
| | ***- Иргүүлж байгаа материал тод гаргацтай байх*** |
| **ТӨЗ 6.2** | Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр: **2020 оны тодотгол Сонгинохайрхан дүүргийн цэцэрлэгүүдийн гоймон нийлүүлэгчийг сонгон шалгаруулах харьцуулалтын тендер**<br><br>Тендерийн дугаар ***ХХТ/202006009/01*** |

Худалдан авах барааны талаарх дор дурдсан өгөгдлүүд нь тендерт оролцогчид өгөх зааварчилгаа/ТӨЗ/-ны холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах, эсхүл өөрчлөх зорилготой. Хэрэв ТӨЗ-ны зүйл, заалттай зөрчилдвөл энэхүү хүснэгт дэх мэдээллийг зөв гэж үзнэ.

## Гурав. **ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

1. **Барааны тодорхойлолт:** Монгол Улсын “Хүнсний тухай хууль”, “ Хүнсний аюулгүй байдлыг хангах тухай” хуулийн заалтыг хангасан байх шаардлагатай бөгөөд хүний бие махбодын хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг дэмжих, үндсэн шимт бодис, эрдэс, амин дэмийн зохистой хэмжээ агуулагдсан байх. Монгол Улсын олон Олон улсын шаардлага хангасан түүхий эд, бүтээгдэхүүн нийлүүлж, хүний эрүүл мэндийг дэмжин хамгаалах шаардлагатай хүнсийг зөвхөн Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээдээс импортлон авах ба экспортлогч улсын үйлдвэртэй шууд, эсхүл түүний албан ёсны гэрээт борлуулагчтай худалдааны гэрээ байгуулсан байх, тухайн гэрээт нийлүүлэгч нь стандарт техникийн зориулалтын шаардлага хангасан зориулалтын агуулах, тээврийн хэрэгсэлтэй байх, эсхүл энэ шаардлагыг хангасан хуулийн этгээд, байгууллагатай гэрээтэй байх ёстой. Хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэгч нь эрүүл ахуйн шаардлага хангасан чанартай бүтээгдэхүүн нийлүүлэх, дагалдах шинжилгээний бичгүүдийг нийлүүлэлт тухай бүрд тогтмол өгч байх шаардлагатай.

2. **Стандарт:** *Тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно.* бичнэ

3. **Баглаа, боодол:** Баглаа, боодол: Нийлүүлэгч нь бүтээгдэхүүнийг зориулалтын уутанд савлаж, дараах мэдээллийг агуулсан шошго хийж битүүмжилнэ. Үүнд:
   - Үйлдвэрлэгчийн нэр
   - Бүтээгдэхүүний нэр, төрөл
   - Цэвэр жин
   - Үйлдвэрлэсэн огноо, хадгалах хугацаа
   - Стандартын дагуу
   - Хэрэглэх аргын заавар

   Бүтээгдэхүүнийн тээвэрлэхдээ ус чийг, шороо тоосноос хамгаалсан зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.

4. **Бараа хүргэх газар:** Хүнс хангамж төв ОНӨААТҮГ өөрийн агуулах

### Техникийн тодорхойлолт

| № | Багц дугаар | Багц нэр | Бүтээгдэхүүний нэр төрөл | Техникийн тодорхойлолт болон стандарт | Сав баглаа боодол |
|---|---|---|---|---|---|
| 1 | Багц X/1 | Гоймон нийлүүлэх | Гоймон хэлбэрт | MNS0142:1985 | Зориулалтын уутанд савласан 5кг савлагаатай |
| 2 | | | Шпагетти | MNS0142:1985 | Зориулалтын уутанд савласан 300гр савлагаатай |
| 3 | | | Гоймон туузан | MNS0142:1985 | Зориулалтын уутанд савласан 5кг савлагаатай |

5. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

**БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ**

<table>
<tr><th rowspan="3">Багц нэр</th><th rowspan="3">Барааны тодорхойлолт</th><th rowspan="3" colspan="2">Тоо ширхэг</th><th rowspan="3">Хэмжих нэгж</th><th rowspan="3">ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг (Ажлын талбай)</th><th colspan="5">Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа</th></tr>
<tr><th rowspan="2">Бараа нийлүүлэх хамгийн эхний хугацаа</th><th rowspan="2">Бараа нийлүүлэх эцсийн хугацаа</th><th rowspan="2">Бараа нийлүүлэх хуваарь</th><th rowspan="2">Бараа нийлүүлэх хэмжээ</th><th>Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа</th></tr>
<tr><th>(Тендерт оролцогч энэ баганыг бөглөнө)</th></tr>
<tr><td>1</td><td>2</td><td colspan="2">3</td><td>4</td><td>5</td><td>6</td><td>7</td><td>8</td><td>9</td><td>10</td></tr>
<tr><td rowspan="3">Гоймон</td><td rowspan="3">Ангилсан зориулалтын уутанд савласан үхрийн мах</td><td>Гоймон хэлбэрт</td><td>7500</td><td>кг</td><td rowspan="3">"Хүнс хангамж төв" ОНӨААТҮГ-ын агуулах</td><td rowspan="3">2020.09.01</td><td rowspan="3">2020.12.31</td><td rowspan="3">Захиалгын дагуу</td><td>500-1000кг</td><td rowspan="3"></td></tr>
<tr><td>Шпагетти</td><td>7550</td><td>ш</td><td>300-500ш</td></tr>
<tr><td>Гоймон туузан</td><td>2400</td><td>кг</td><td>54-100кг</td></tr>
</table>

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

## 1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

*[огноо]*

***(Захиалагч байгууллагын нэр)****-ын* дарга __________________ танаа

1. Бид, *[тендерт оролцогчийн нэр]* дор дурдсан барааг ***[санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр]*** төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу ***[тоо]*** хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.

2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.

3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

| Нэр төрөл | Тодорхойлолт | Барааны гарал үүслийн улс | Тоо ширхэг | Нэгж үнэ | Нийт дүн | НӨАТ болон бусад албан татвар | Бүгд дүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| Тендерийн нийт үнэ | | | | | | | |

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

   Баталгаат засварын хугацаа:

   Санал болгож буй бусад нөхцөл:

   Тендерт оролцогчийн нэр:

   Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

   Албан тушаал, нэр:

   Хаяг:

**МАЯГТ №: ТШМ-2А**

**МОНГОЛ УЛСАД ҮЙЛДВЭРЛЭГДСЭН БАРААНЫ ҮНИЙН ХУВААРЬ**

(А ангилал)

Огноо:_________________
НТШ-ын дугаар: ______________
Тендерийн урилгын дугаар: ___
Хувилбарт тендерийн дугаар: _________
Хуудасны ____ -ын _____ дугаар ___

ТОӨЗ-ны 16-д заасан валютаар

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Нэр төрөл | Барааны тодорхойлолт | Гарал үүслийн улс | Тоо ширхэг болон эд анги | EXW нэгж үнэ | Нэр төрөл бүрийн EXWбүгд үнэ (4x5) | Барааг эцсийн цэгт хүргэхэд шаардагдах дотоодын тээвэрлэлт болон бусад үйлчилгээний үнэ (хэрэв ТШӨХ, ТОӨЗ-ны 15.9.(а).(3)-д шаардсан бол) | Монгол улсын нутаг дэвсгэр дээр бий болсон буюу дотоодын ажиллах хүч, түүхий эд болон бусад үйлчилгээний өртөгийн 6-р баганад заасан үнэд эзлэххувь | ТОӨЗ-ны 15.9(а).(2)-д заасан гэрээ байгуулах эрх олгосон тохиолдолд төлөх НӨТ болон бусад татвар хураамж | Нэр төрөл бүрийн нийт үнэ (6+7+9) |
| | | | | | | | | | |
| **Тендерийн нийт үнэ (10)** | | | | | | | | | |

Тендерт оролцогчийн нэр ___________________ Гарын үсэг ____________________ Огноо ____________________

***Жич: үнийн хувиарыг сар тус бүрээр задлаж ирүүлнэ.***

**МАЯГТ №: ТШМ -2Б**

**МОНГОЛ УЛСЫН ГАДНА ҮЙЛДВЭРЛЭГДСЭН БӨГӨӨД ИМПОРТООР ОРЖ ИРЭХ БАРААНЫ ҮНИЙН ХУВААРЬ**

Огноо: ______________________

НТШ-ын дугаар: ___________________

Тендерийн урилгын дугаар: ________

(Б ангилал) Хувилбарт тендерийн дугаар: _______

Хуудасны ________ –ын _______

ТОӨЗ-ны 16-д заасан валютаар

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Нэр төрөл № | Бараан ы тодор-хойлол т | Гарал үүслийн улс | Тоо ширхэг | ТОӨЗ-ны 15.9 (б) (1)-д заасан СИФ эсхүл СИП нэгж үнэ | Нэр төрөл бүрийн СИФ эсхүл СИП нийт үнэ (4 x 5) | Барааг эцсийн цэгт хүргэхэд шаардагдах дотоодын тээвэрлэлт болон бусад үйлчилгээний үнэ (хэрэв ТШӨХ, ТОӨЗ-ны 15.9(б).(3)-д шаардсан бол) | ТОӨЗ-ны 15.9(б).(2)-д зааснаар гэрээ байгуулах эрх олгосон тохиолдолд төлөх НӨТ болон бусад татвар хураамж | Нэр төрлийн нийт дүн (6 + 7+8) |
| | | | | | | | | |
| **Тендерийн нийт дүн (9)** | | | | | | | | |

Тендерт оролцогчийн нэр ___________________ Гарын үсэг ____________________ Огноо ___________________

***Жич: үнийн хувиарыг сар тус бүрээр задлаж ирүүлнэ.***

**МАЯГТ №: ТШМ -2В**

**МОНГОЛ УЛСЫН ГАДНА ҮЙЛДВЭРЛЭГДСЭН БӨГӨӨД ИМПОРТООР ОРУУЛЖ ИРСЭН БАРААНЫ ҮНИЙН ХУВААРЬ**

Огноо: ______________________
НТШ-ын дугаар: ___________________
Тендерийн урилгын дугаар: ________
(В ангилал) Хувилбарт тендерийн дугаар: _______
Хуудасны ________ –ын _______

ТӨЗ-ны 16-д заасан валютаар

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Нэр төрөл № | Барааны тодорхойлолт | Гарал үүслийн улс | Инкотермд тусгасны дагуу хүргэх огноо | Тоо ширхэг | ТӨЗ-ны 15.9 (в) (1)-д заасан урьд нь төлсөн болон төлөх гаалийн татвар хураамж болон импортын татварыг оруулсан нэгж үнэ | ТӨЗ-ны 15.9(в).(2)-д заасан нэр төрөл бүрт төлсөн гаалийн болон импортын татвар хураамж [нотлох бичиг баримтыг үндэслэнэ] | ТӨЗ-ны 15.9 (в) (3)-д заасны дагуу нэгж үнэ (гаалийн татвар хураамж болон импортын татварыг хассан) (6 – 7) | ТӨЗ-ны 15.9 (в) (3) (9=8x5)-д заасны дагуу гаалийн болон импортын татварыг хассан нэр төрөл бүрийн үнэ | Барааг эцсийн цэгт хүргэхэд шаардагдах дотоодын тээвэрлэлт болон бусад үйлчилгээний үнэ (ТӨЗ-ны 15.9(в) (5)-д шаардсан бол) | Гэрээ байгуулах эрх олгосон тохиолдолд төлөх НӨТ болон бусад татвар хураамж | Нэр төрөл бүрийн нийт үнэ (9+10+11) |
| | | | | | | | | | | | |
| **Тендерийн нийт үнэ (12)** | | | | | | | | | | | |

**Тендерт оролцогчийн нэр ___________________ Гарын үсэг ____________________Огноо ____________________**
***Жич: үнийн хувиарыг сар тус бүрээр задлаж ирүүлнэ.***

**5. Чадварын мэдээлэл ирүүлэх маягтууд**

**МАЯГТ №: ТШМ-5А**

**Санал болгож буй туслан гүйцэтгэгч**

| | Зүйл | Туслан гүйцэтгэгчийн нэр | Бүртгэгдсэн газар болон чадавхи |
|---|---|---|---|
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |

**МАЯГТ №: ТШМ-5Б**

## Ижил төрлийн гэрээ гүйцэтгэсэн туршлага

| Тендерт оролцогч эсхүл түншлэлийн гишүүний нэр |
|---|

Гэрээ тус бүрээр маягтыг бөглөнө.

| | | |
|---|---|---|
| 1. | Гэрээний дугаар | |
| | Гэрээний нэр | |
| | Улсын нэр | |
| 2. | Захиалагчийн нэр | |
| 3. | Захиалагчийн хаяг | |
| 4. | ТББ-д тодорхойлсон гэрээтэй холбогдох ижил төрлийн болон бусад онцлог | |
| 5. | Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох)<br>☐Үндсэн нийлүүлэгч ☐ Туслан гүйцэтгэгч ☐ Түншлэлийн гишүүн | |
| 6. | Гэрээ/туслан гүйцэтгэх гэрээ/түншлэлийн хувьд ногдох гэрээний дүн/-ний үнийн дүн (гэрээ байгуулагдах эсхүл дуусгавар болсон үеийн мөнгөний нэгжээр илэрхийлсэн гэрээний дүн байна)<br>Мөнгөний нэгж Мөнгөний нэгж Мөнгөний нэгж | |
| 7. | Гэрээний дүн:_______; Туслан гүйцэтгэх гэрээ: _______; Түншлэлийн хувьд ногдох гэрээний дүн: _______; | |
| 8. | Гэрээ байгуулсан/дуусгавар болсон огноо | |
| 9. | Гэрээ нь хуваарьт хугацаанаас _____ сарын өмнө/дараа дууссан. (хэрэв хоцорч дууссан бол тайлбарлах) | |
| 10. | Гэрээ нь гэрээний үндсэн үнийн дүнгээс _________ дутуу/илүү дүнгээр дуусгавар болсон. (хэрэв илүү гарсан бол тайлбарлах) | |
| 11. | Техникийн тусгай шаардлагууд. | |
| 12. | Нийт гэрээний үнийн дүнд туслан гүйцэтгэх гэрээгээр гүйцэтгэсэн дундаж хувийн жин, тухайн эх сурвалжийг тусгах. | |

**МАЯГТ №: ТШМ-5В**

## Нэгдсэн хүснэгт: Одоо хэрэгжиж буй гэрээ

| Тендерт оролцогч эсхүл түншлэлийн гишүүний нэр |
| --- |

Тендерт оролцогч болон түншлэлийн гишүүн бүр өөрсдийн хэрэгжүүлж буй буюу одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ. Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

| Гэрээний нэр | Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс | Гэрээний үнийн дүн | Гэрээг дуусгахаар төлөвлөсөн хугацаа | Дараагийн 6 сард нэхэмжлэх үнийн дүнгийн сарын дундаж |
| --- | --- | --- | --- | --- |
| 1. | | | | |
| 2. | | | | |
| 3. | | | | |
| 4. | | | | |
| 5. | | | | |
| бусад. | | | | |

**МАЯГТ №: ТШМ-5Г**

## Санхүүгийн чадавхи

| Тендерт оролцогч эсхүл түншлэлийн гишүүний нэр |
|---|

Тендерт оролцогч түншлэлийн гишүүн бүрийг оролцуулан ТӨЗ-ны 18.2 (а) заалт болон түүнд харгалзах ТШӨХ-д заасан шаардлагыг хангаж буйг харуулсан санхүүгийн мэдээллийг ирүүлнэ. Тендерт оролцогч эсхүл түншлэлийн гишүүн бүр энэ маягтын дагуу өөрийн холбогдох мэдээллийг ирүүлнэ. Шаардлагатай бол банкны мэдээллийн хүснэгтийг тус тусдаа бөглөнө. Татварын албанд тушаасан (захиалагч шаардсан бол аудитаар баталгаажуулсан байх) санхүүгийн тайланг нотлох баримт болгон энд хавсаргана.

| Банк | Банкны нэр | |
|---|---|---|
| | Банкны хаяг | |
| | Утас | Холбоо барих ажилтны нэр, албан тушаал |
| | Факс | Телекс |

Сүүлийн (**ТШӨХ-д заасан тоо**) хүртэлх жилийн хугацааны нийт хөрөнгө болон эх үүсвэрийг төгрөгөөр (хөрвүүлэх ханш нь тухайн жил бүрийн эцсийн байдлаар мөрдөгдөж байсан Монголбанкны зарласан ханш байна) илэрхийлнэ.

| Санхүүгийн мэдээлэл /сая/ | Сүүлийн (**ТШӨХ-д заасан тоо**) хүртэлх жилийн хугацаанд | | | | | Төлөвлөсөн: Дараагийн 2 жилийн хугацаанд | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 5 | 4 | 3 | 2 | 1 | 1 | 2 |
| 1. Нийт хөрөнгө | | | | | | | |
| 2. Эргэлтийн хөрөнгө | | | | | | | |
| 3. Нийт өглөг | | | | | | | |
| 4. Эргэлтийн өглөг | | | | | | | |
| 5. Татварын өмнөх ашиг | | | | | | | |
| 6. Татварын дараах ашиг | | | | | | | |

Санал болгож буй санхүүгийн эх үүсвэр буюу ТӨЗ-ны 18.2 (а) заалт болон түүнд харгалзах ТШӨХ-д заасан шаардлагыг хангаж гэрээг гүйцэтгэх явцад хүрэлцэхүйц эргэлтийн хөрөнгийн эх үүсвэртэйг харуулсан хөрвөх хөрөнгө, зээл авах боломж буюу зээлжих баталгаажсан эрх болон бусад санхүүгийн хэрэгслийг тодорхойлно.

| Эргэлтийн хөрөнгө, санхүүгийн бусад эх үүсвэр | Дүн |
|---|---|
| 1. | |
| 2. | |
| 3. | |
| 4. | |

ТӨЗ-ны 18.2 (а) заалт болон түүнд харгалзах ТШӨХ-д заасан хугацааны (тендер оролцогч эсхүл түншлэлийн гишүүн бүр) аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан, түүнд хийсэн тайлбарыг хавсаргана.

Хэрэв тендерт оролцогчийн улсын хуулиар аудитын баталгааг шаарддаггүй бол хувийн байгууллагын санхүүгийн тайланг эрх бүхий бүртгэгдсэн нягтлан бодогч болон татварын байгууллагын тодорхойлолтын хуулбарыг хавсаргана.

**МАЯГТ №: ТШМ-5Д**

## Ажиллах хүчний чадавхи

| Тендерт оролцогчийн нэр |
|---|

Тендерт оролцогч нь гэрээний удирдлага болон хэрэгжилтийг хариуцан ажиллахтай холбогдох ур чадвар, мэргэжлийн шаардлагыг хангасан, хамгийн багадаа 2 хүний нэрийг албан тушаал тус бүрт дэвшүүлнэ. Нэр дэвшигч бүрийн ажлын туршлагын талаарх мэдээллийг тус тусад нь гаргаж ирүүлнэ.

Тендерт оролцогч нь гэрээг удирдах, хэрэгжилтийн зохион байгуулах хувилбарт нэр дэвшигчийн ажлын туршлага, ур чадварын талаарх мэдээллийг мөн ирүүлнэ.

| | |
|---|---|
| 1. | Албан тушаал |
| | Үндсэн нэр дэвшигчийн нэр |
| | Хувилбарт нэр дэвшигчийн нэр |
| 2. | Албан тушаал |
| | Үндсэн нэр дэвшигчийн нэр |
| | Хувилбарт нэр дэвшигчийн нэр |
| 3. | Албан тушаал |
| | Үндсэн нэр дэвшигчийн нэр |
| | Хувилбарт нэр дэвшигчийн нэр |
| 4. | Албан тушаал |
| | Үндсэн нэр дэвшигчийн нэр |
| | Хувилбарт нэр дэвшигчийн нэр |

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхгүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

| Гэрээний нэр | Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс | Гэрээний үнийн дүн | Гэрээний эхлэх хугацаа | Гэрээний дуусах хугацаа |
|---|---|---|---|---|
| 1. | | | | |
| 2. | | | | |
| 3. | | | | |
| 4. | | | | |
| 5. | | | | |
| бусад. | | | | |

Тав. **ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ**

| | |
|---|---|
| **1. Шалгах болон турших** | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| **2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт** | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| **3. Оюуны өмчийн эрх** | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| **4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх** | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| **5. Баталгаат засварын хугацаа** | 5.1 Гэрээний ерөнхий нөхцөлийн 13 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. |
| **6. Гэрээнд өөрчлөлт оруулах** | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| **7. Төлбөр** | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш ***[ГТН-д заасан тоо]*** хоногийн дотор шуурхай хийнэ. |
| **8. Бараа нийлүүлэх хуваарь** | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| **9. Алданги оногдуулах** | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| **10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах** | 10.1 (а) нийлүүлэгч аль нэг болон бүх барааг гэрээнд заасан эсвэл ГЕН-ийн 16 дугаар зүйлийн дагуу сунгасан хугацаанд 2 удаа хүргэж чадаагүй;<br><br>(б) нийлүүлэгчийн ирүүлсэн бараа нь техникийн тодорхойлолтын шаардлага хангаагүй бөгөөд (ГЕН-7) заасан үүргээ биелүүлээгүй;<br>(г)нийлүүлэгч тендер шалгаруулалтад оролцох, гэрээ байгуулах, хэрэгжүүлэхдээ авлигал, залилан мэхлэх зохиомол тохиролцоо хийх болон айлган сүрдүүлэх үйлдэлд холбогдсоныг |

## Зургаа. **ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ**

| | | |
|---|---|---|
| **1. Шалгах болон турших (ГЕН – 1)** | 1.1. | Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-аас байгууллагын “дотоод хяналт, шалгалтын журам”-ын дагуу эрх бүхий ажилтан бүтээгдэхүүн, үйлчилгээ, ажлын байранд үзлэг шалгалтыг зохион байгуулан шаардлагатай нөхцөлд харьяа мэргэжлийн хяналтын байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ. |
| **2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)** | 2.1. | Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:<br><br>1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;<br>2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;<br>3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;<br>4) Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 9.1-д заасны дагуу, Үйлдвэр, Хөдөө аж ахуйн сайдын 2014 оны 8 сарын 6-ны өдрийн А/98 тоот журмын дагуу хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн хуудас болон шаардлагатай тохиолдолд энэ журмын 2.7-2.12 дугаар зүйлд заасан баримт бичгийг тус тус дагалдуулна.;<br>5) барааны гарал үүслийн гэрчилгээ.<br><br>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна. |
| **3. Баталгаат засвар (ГЕН-5)** | 5.1. | Баталгаат засварын тусгай шаардлага.<br><br>Гэрээний ерөнхий нөхцөлийн 13 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Дараах эрсдэлүүдийг гүйцэтгэгч хариуцна. Үүнд:<br>▪ Бүтээгдэхүүний сав баглаа боодол гэмтсэн<br>▪ Стандарт шаардлага хангаагүй.<br>▪ Бүтээгдэхүүний хадгалалтын хугацаа дуусах дөхсөн /тухайн бүтээгдэхүүний хадгалалтын хугацааны 1/3 хугацаа нь үлдсэн байх/ болон дууссан бол тухайн бүтээгдэхүүнийг солиулах<br>▪ Бүтээгдэхүүнийг хүлээн авах үед мэдэгдэх боломжгүй байсан далд гэмтэл зэрэгт доголдлыг арилгуулах, гэмтэл доголдолгүй ижил төрлийн стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүнээр солиулах |
| **4. Төлбөр (ГЕН – 7)** | 7.1. | Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:<br><br>Барааг хүлээн авахад төлөх төлбөр: Захиалагч бараа нийлүүлэлтийн хуваарьт заасны дагуу барааг хүлээн авсан тухай бүр бараа хүлээн авсан актыг үндэслэн 60 хоногийн дотор тухайн хүлээн авсан барааны төлбөрийг төлнө. |
| **5. Алданги оногдуулах (ГЕН - 9)[1]** | | Алданги оногдуулах хувь: хугацаа хэтэрсэн долоо хоног тутамд гэрээний гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,1 хувь байна.<br><br>Алдангийн нийт дүн нь гэрээний үнийн дүнгийн 5 хувь байна. |

[1] Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

Долоо. **ГЭРЭЭНИЙ МАЯГТ**[2]

**БАТЛАВ.**

| **ЗАХИАЛАГЧ** | **НИЙЛҮҮЛЭГЧ** |
|---|---|
| (Тамга, тэмдэг) | (Тамга, тэмдэг) |
| (Гарын үсэг) | (Гарын үсэг) |
| (Албан тушаал) | (Албан тушаал) |

***[Тендер шалгаруулалт/гэрээний нэр]*** **гэрээ.**

Дугаар № *[Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]*

.............................. хот/аймаг

Нэг талаас ***[захиалагчийн нэр]*** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас ***[нийлүүлэгчийн нэр]*** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ___ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь *[гэрээний нэр, дугаар]*-г (цаашид “бараа” гэх) ***[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]*** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг ____________ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, ____________ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, ____________ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

4. Нийлүүлэгч нь ____________________________________________________ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ___-нас _____ оны __ дугаар сарын ___-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

    Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
    Бусад шаардлагатай баримт бичиг[3];
    Үнийн санал;
    Гэрээний тусгай нөхцөл;
    Гэрээний ерөнхий нөхцөл;
    Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
    Санхүүжилтийн хуваарь.

[2] Гэрээ байгуулах үед үүнийг хасна.
[3] Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.

7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

| **ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:** | **НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:** |
|---|---|
| *[Албан тушаал, нэр]*<br>*[Гарын үсэг]*_________________________ | *[Албан тушаал, нэр]*<br>*[Гарын үсэг]*_________________________ |
| ТАМГА | ТАМГА |
| *[Захиалагчийн хаяг]*<br>*[Утас/факсын дугаар]*<br>*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]* | *[Захиалагчийн хаяг]*<br>*[Утас/факсын дугаар]*<br>*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]* |